*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ХАЯГДАЛ УСНЫ ТӨЛБӨР, ТООЦОО ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН БАЯРСАЙХАНЫ БОЛОР-ЭРДЭНИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: УСНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ, ДАХИН АШИГЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, УС БОХРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ТОГТООМЖ, БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ**<br>Стратеги төлөвлөгөөний зорилго 1: Усны нөөцийг тогтоох, усны нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, бохирдол, хомсдлоос сэргийлэх<br>“Алсын хараа 2050” хөтөлбөрийн зорилт 5.1.2, 6.3, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 6.3.1, ЗГ-ын 2024-2028 оны ҮАХ-ийн 2.4.3.6, 2.4.3.7, 3.4.1.7, 3.4.2.5, 3.4.3.4, 4.3.1.4, БОУАӨЯ-ны стратегийн зорилт 4.1,4.2,4.3,4.4,4.5; Усны газрын стратеги төлөвлөгөөний 1.1, 1.2, 1.3, 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.5, 2.6.2.7 | | | | | | | |
| **Зорилт 1:** Усыг дахин ашиглах бодлогын хэрэгжилтийг хангах, дахин ашиглалтын нөөц бүрдүүлэх төлөвлөлтийг хэрэгжүүлэн мэдээллийг тайлагнах. | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1.**<br>Ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх, урамшууллын механизмыг хэрэгжүүлж мэдээг Татварын албанд хүргүүлсэн байх. | Хүргүүлсэн мэдээний тоо | 4 | Эхний хагас жил: Ус бохирдуулагчдын 2024 оны IV улирал, 2025 оны I улирлын хөнгөлсөн, чөлөөлсөн төлбөрийг тооцож, Татварын албанд хүргүүлсэн байна. | Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 8.1.2 дахь заалтын дагуу 46 аж ахуйн нэгж, байгууллагын дахин ашигласан хаягдал усны 729 сая төгрөгийн төлбөрийг бүрэн чөлөөлж, мөн хуулийн 8.3 дахь заалтаар төсвөөс санхүүждэг боловсролын салбарын 235 байгууллагаас 28 сая төгрөг, эрүүл мэндийн салбарын 59 байгууллагаас 13.05 сая төгрөгийг хөнгөлж, хот, суурин газрын цэвэрлэх байгууламжид бохир ус нийлүүлсэн 3022 хуулийн этгээдэд 75.12 сая төгрөг ногдуулж, цэвэрлэх байгууламж хариуцсан хуулийн этгээдийн төлбөрөөс хөнгөлж, чөлөөлсөн төлбөрийг тооцож 2024 оны 12 сарын 15 болон 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрүүдэд татварын ерөнхий газарт цахимаар хүргүүлсэн. | 1-6 | 100% |
| **Зорилт 2.** Хаягдал усны хэмжээ, чанарын хяналт шинжилгээ, төлбөр, хууль дүрэм журам, стандартын хэрэгжилтийг нэгтгэн тайлагнах. | | | | | | | |
| 2. | **Арга хэмжээ 2.1.** | | 2024 онд 5 хүсэлтийн дагуу хаягдал | Эхний хагас жил: Хаягдал усны дүгнэлтийг хууль дүрэм журамд нийцүүлэн | Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтын дагуу нийт 50 хаягдал усны дүгнэлтийг 100% цахимаар гаргаж 145.8 сая төгрөгийг | 1-6 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Хуульд заасан чиг үүргийн дагуу хаягдал усны дүгнэлт гаргах | Шийдвэр-лэсэн хүсэлтийн хувь | усны дүгнэлт 100 хувь гаргасан. | хуулийн хугацаанд нь 100 хувь цахимаар гаргасан байна. | ноогдуулан, 79.8 сая төгрөгийг хөнгөлөж, чөлөөлсөн байна. | | |
| | **Арга хэмжээ 2.2.** Ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөр тооцож ногдуулах | Хүргүүлсэн мэдээний тоо | - | Эхний хагас жил: Ус бохирдуулагчдын 2024 оны IV улирал, 2025 оны I улирлын төлбөр, нөхөн төлбөрийг тооцож, Татварын байгууллагад хүргүүлсэн байна. | 50 дүгнэлтээр ус бохирдуулсны төлбөрт 8.2 145.8 сая төгрөг, нөхөн төлбөрт 39.5 сая төгрөг тооцож ногдуулан, Татварын ерөнхий газарт хүргүүлсэн. 2025 оны 01 дүгээр сарын 01-нээс 05 дугаар сарын 31-ний байдлаар 89 сая төгрөг Улсын төсөвт төвлөрсөн байна. | 1-6 | 100% |
| | **Арга хэмжээ 2.3.** Ус ашиглагч аж ахуйн нэгж, байгууллагын хаягдал усны хэмжээ, чанарын төлөв байдалд хяналт тавин шаардлагатай тохиолдолд газар дээр нь хяналтын сорьцын шинжилгээ авч ажиллах. | Хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо | 2 ААНБ-ын хаягдал усанд газар дээр нь хяналтын сорьцын шинжилгээ авч, төлбөр, нөхөн төлбөр ногдуулж, зөвлөмж, шаардлага хүргүүлсэн. | Эхний хагас жил: Урьдчилсан сэргийлэх болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, 3-аас доошгүй бохирдуулагч үйлдвэрүүд болон уул уурхайн технологийн хаягдал уснаас хяналтын сорьцын шинжилгээ авч ажилласан байна. | 2025.01.14-ны өдөр Бид туул гол ТББ-ын гаргасан хүсэлтийн дагуу Усны газар, Туул голын сав газартай хамтран Жин корона ХХК, Нью спэйс ХХК-уудад 01/08 дугаар урьдчилан сэргийлэх удирдамжийн дагуу ноос ноолуур угааж буй үйл ажиллагаанд хяналт тавьж, үйлдвэрээс цэвэрлэн төвлөрсөн шугамруу нийлүүлж буй хаягдал уснаас нийт 4 дээжийг авч шинжилгээнд хамруулан MNS 6561:2024 стандарттай харьцуулахад стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнд байна.<br>Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Салбарын ерөнхий байцаагчийн баталсан 01/08 дугаар удирдамжийн дагуу мах махан бүтээгдэхүүн, өлөн боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанд Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан норм дүрэм, шинээр мөрдөгдөж буй MNS 6561:20241 хэрэгжилтэнд 2025 оны 06 дугаар сарын 05-06-ны өдрүүдэд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. | 1-6 | 100% |
| | **Арга хэмжээ 2.4.** Сав газрын захиргаадын хаягдал усны талаарх дүн мэдээг нэгтгэж, тайлагнах. | Хянаж нэгтгэсэн тайлангийн тоо | - | Эхний хагас жил: Сав газрын захиргаадын гаргасан дүгнэлт, төлбөр, зөвшөөрөл, гэрээний дүн мэдээг улирал бүр цахимаар хүлээн авч, хянан дүн мэдээг 2 удаа | 21 Сав газрын захиргаанаас 2025 оны эхний 5 сарын байдлаар 17 сав газар 3481 хаягдал усны дүгнэлтээр 2.16 сая $м^3$ хаягдал усанд 123.8 сая төгрөг ногдуулсан байна. Үүнээс боловсролын салбарын 397 байгууллагаас 41 сая төгрөг, эрүүл мэндийн салбарын 159 байгууллагаас 35.26 сая төгрөг хөнгөлж, 6631 айл өрхөөс 13.5 | 1-6 | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Татварын албанд хүргүүлсэн байна. | сая төгрөг чөлөөлж, 2892 ус бохирдуулагчид 56.7 сая төгрөг ногдуулсанг 2025 оны 01 дүгээр сарын 01-нээс 05 дугаар сарын 31-ний байдлаар 89 сая төгрөг Улсын төсөвт төвлөрсөн байна. | | |
| **Зорилт 3**: Усны нөөц, горим, чанарын төлөв байдал, өөрчлөлтөд байнгын ажиглалт, хэмжилт, судалгаа шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, мэдээллээр хангах, усны хяналт- шинжилгээний нэгдсэн сүлжээг зохион байгуулж ажиллуулах. | | | | | | |
| 3. | **Арга хэмжээ 3.1.** Говийн бүсийн 3 аймгийн суурин газрын усны чанарт үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах. | Усны чанарын үнэлгээ хийсэн сумын тоо | - | Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгийн 44 сумын усны чанарт үнэлгээ хийх ажлын хуваарь гаргаж, бэлтгэл ажлыг хангасан байна. | БОУАӨСайдын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/275 дугаар "Төсвийн зардлын хуваарьт өөрчлөлт оруулж, эрх шилжүүлэх тухай" тушаалаар 2025 оны А/78 дугаар тушаалыг хүчингүй болгосноор Говийн бүсийн 3 аймгийн суурин газрын усны чанарт үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах ажлын 200 сая төгрөг хасагдаж, ажлыг зогсоосон байна. Усны хяналтын төв лаборатори Дорноговь аймгийн Улаанбадрах сум болон Сайншанд сумын малчдын унд ахуйн гүний худгуудаас 2 удаагийн давтамжтай, 8 цэгээс дээж авч хими, нянгийн шинжилгээг хийж усны газрын даргад гарсан үр дүнг танилцуулж, "БАДРАХ ЭНЕРЖИ" ХХК-д дүгнэлт зөвлөмж хүргүүлэн, цаашид давтамжийг сар бүр тогтмол авч цооног болон ойр орчмын гүний худгуудаас мониторинг хийх ажлын төлөвлөгөө гаргаж , ажлын хэсгийн ахлагч Ус ашиглалтын хэлтсийн дарга /Х.Мягмаржав/-д өгч ажилласан. | 1-6 | 100% |
| **Зорилт 4:** Улсын усны төв лабораторийн тасралтгүй үйл ажиллагааг хэрэгжүүлж, усны бохирдлыг бууруулах суурь мэдээллийг бүрдүүлэх, шинжилгээ хийх | | | | | | |
| | **Арга хэмжээ 4.1.** Хөвсгөл нуурт хийгдсэн судалгааг үндэслэн экосистемийн бохирдлын эрсдэлийг бууруулах төлөвлөгөө гарган, төлөвлөгөөний дагуу хийгдэх ажлыг эхлүүлэх. | Төлөвлөгөө -1 | Хөвсгөл нуурын экосистемийн бохирдлын эрсдэлийг бууруулах судалгаа хийсэн. | ***Эхний хагас жил***: Судалгааны зөвлөмжийг үндэслэн төлөвлөгөө гаргаж батлуулах. | Хөвсгөл нуурын экосистемийн бохирдлын эрсдэлийн судалгааны явцад гарсан зөвлөмжүүдийг үндэслэн Хөвсгөл нуурын экосистемийн бохирдлын эрсдэлийг бууруулах зорилгоор хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, БОУАӨЯ-д хүргүүлсэн. | 1-6 | 100% |
| | **Арга хэмжээ 4.2.** Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан | Албан мэдэгдэл хүргүүлсэн хувь | - | ***Эхний хагас жил:*** Ариун цэврийн байгууламж, цэвэрлэх байгууламжийн судалгаа гаргасан байна. | Монгол Улсын хэмжээнд бүртгэлтэй нийт 700 гаруй Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид олборлолт явуулж байгаа бөгөөд эдгээрийн 40 хувь буюу 280 нь стандартын шаардлага | 1-6 | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | зохицох зорилгоор уул уурхайн ажилчдын хотхоныг ариутгах татуургын хувьд бие даасан, байгальд ээлтэй, ариун цэврийн байгууламжтай болгох ажлыг зохион байгуулах хүрээнд албан мэдэгдэл хүргүүлэх. | | | хангасан цэвэрлэх байгууламжтай, 50 хувь буюу 350 нь түр шийдэл (зөөврийн жорлон, септик систем гэх мэт) ашиглаж байгаа бол 10 хувь буюу 70 нь ариун цэврийн байгууламжийн хувьд бүрэн шийдэлгүй, шаардлага хангахгүй нөхцөлд үйл ажиллагаа эрхэлж байна. | | |
| | **Арга хэмжээ 4.3.** Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 53 дугаар тогтоолоор баталсан "Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө"-нд заасны дагуу урьдчилан цэвэрлэх байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг эхлүүлэхээр шаардлага хүргүүлэх. | Шаард-лагын тоо-70 | - | ***Эхний хагас жил:*** Бохирдуулагч үйлдвэр, үйлчилгээний салбарын хаягдал усны хяналтыг хэрэгжүүлж, технологид нийцсэн цэвэрлэх байгууламжтай болгох талаар судалгаанд авагдсан 70 үйлдвэрт шаардлага хүргүүлсэн байна. | Засгийн газрын 2021 оны 53 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд бохирдуулагч 70 үйлдвэртэй утсаар холбогдож хэрэгжилтийн явцыг тодруулсан.<br>Очир Дагинас ХХК, Жүр Үр ХХК нь бохир усны цэвэрлэх байгууламжийг шинээр байгуулсан бол АПУ ХК 2025 оны 6 дугаар сарын 10-нд шав тавих ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байна. ТЭСО ХХК цэвэрлэх байгууламжийнхаа зураг төслийг батлуулсан. Бусад аж ахуйн нэгжүүд зураг төсөл боловсруулах, хуучин байгууламжаа шинэчлэх, эсвэл газар талбайн боломжгүй зэрэг шалтгаанаар хэрэгжилтийн судалгааны шатанд байна. Судалгааны мэдээллийг БОУАӨЯам, ХББОСЯам, ММССанд хүргүүлсэн. | 1-6 | 100% |
| **Зорилт 5.** Агентлагийн хэвийн үйл ажиллагааг хангаан, хууль тогтоомжийн хэрэгжилтийг түгээн дэлгэрүүлэх, олон нийттэй харилцах | | | | | | |
| 5. | **Арга хэмжээ 5.1.** Төрөөс усны талаар баримтлах дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүд болон Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын уялдааг сайжруулах, чадавхжуулах ажлыг зохион байгуулах. | Арга хэмжээний тоо | Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын уялдааг сайжруулах чиглэлээр 1 удаагийн ажил зохион байгуулсан. | Эхний хагас жил: 1. Ус бохирдуулсны төлбөрийн мэдээллийг ewater.mn цахим системээр Татварын албанд хүргүүлэх ажлыг зохион байгуулсан байна.<br>2. Сав газрын захиргаадын албан хаагчдыг цахим системд ажиллах талаар мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажилласан байна. | Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглан үйлчилгээг зохицуулах хорооноос зохион байгуулж буй "Усны шинжилгээний лабораторийн химич, бактерлогичийг чадавхжуулах" сургалтанд Усны тухай хууль, ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулиуд болон шинээр хэрэгжиж буй MNS 6561:2024 стандарт шинжилгээний дүн боловсруулахад анхаарах асуудлуудын талаар 16 албан хаагчдад мэдээлэл өгч сургалт зохион байгуулж ажилласан.<br>Ewater.mn цахим системээр ирүүлсэн 50 дүгнэлтээс 33 дүгнэлтийг шийдвэрлэж, Татварын ерөнхий газарт 2025 оны 04 дүгээр | 1-6 | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | сарын 15 өдөр цахимаар хүргүүлж, 13 дүгнэлтийг харъяа сав газрын захиргаанд шилжүүлж, 4 дүгнэлтийг боловсруулж байна. | | |
| | **Арга хэмжээ 5.2.** Олон нийтийн устай холбоотой хэвшмэл ойлголтыг өөрчлөх, хууль тогтоомжтой холбоотой асуудлыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах. "Цэнхэр алт"" үндэсний чуулган зохион байгуулах. Иргэд, олон нийтийг мэдээллээр хангах ажил зохион байгуулах" | 2024 онд "Цэнхэр тууз" аяныг зохион байгуулсан | Эхний хагас жил: Олон нийтийн хамтын ажиллагааг өргөжүүлж, усны тухай хууль, тогтоомжуудыг сурталчлах хүрээнд "Дэлхийн усны өдөр"-ийг тохиолдуулан сарын аян зохион байгуулах. | "Дэлхийн усны өдөр"-ийг тохиолдуулан "ЦЭНХЭР АЛТ" Усны салбарын Үндэсний II чуулганыг 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр ТӨРИЙН ОРДНЫ ИХ МОНГОЛ ТАНХИМД зохион байгуулсан бөгөөд чуулганд оролцогчдын мандат олгох мөн хэрсний бохирдол гүний усыг бохирдуулж буй талаар мэдээлэл бэлтгэн усны газрын AI туслах болох MG-ээр мэдээллийг олон нийтэд түгээсэн. | 1-6 | 100% |
| | **Арга хэмжээ 5.3.** Агентлагийн үйл ажиллагаанд хуулиар хориглоогүй мэдээллийг олон нийт, иргэдэд ил тод, нээлттэй байлгах, мэдээлэл авах эрх тэгш боломжоор хангах. Үнэлгээний хувь | shilen.gov.mn системийн хэрэгжилт 20 хувьтай | Эхний хагас жил: Цахим сайтуудад оруулах мэдээллийг тухай бүр бүрэн оруулж shilen.gov.mn системийн үнэлгээг 50 хувьд хүргэх. | Байгууллагын water.gov.mn сайтын Үйлчилгээ цэс дэх хаягдал усны дүгнэлт хэсэгт 2025 оны эхний хагас жилийн дүн мэдээг хүснэгт болон графикаар шинэчлэн байршуулсан. Шинэчлэн боловсруулсан "Хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээ"-ний төслийг water.gov.mn сайтын Ил тод байдал цэсний Үйл ажиллагааны ил тод байдал хэсэгт санал авахаар байршуулсан. | 1-6 | 100% |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | **Үүрэг даалгавар 1.** Дэд бүтэц, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, химийн бодисын төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан хэлэлцэх хуралд Усны газрыг төлөөлж гишүүнээр ажиллах. | Оролцсон хурлын тоо | - | - | 2025 оны эхний хагас жилийн байдлаар 5 удаа хуралдаж, нийт 69 төслийг хэлэлцсэнээс 22 баталж, 26 татгалзан, 18 засварт буцаасан байна. | 1-6 | 100% |
| 2. | **Үүрэг даалгавар 2.** Гэр хорооллын 200,000 гаруй өрхийн 144,992 нь нүхэн жорлон ашиглаж байгаа бөгөөд | - | - | Санхүүжилтыг шийдвэрл | Сэлбэ голын усны чанарт нүхэн жорлонгийн нөлөөллийг үнэлгээ, зураглал хийж зөвлөмж боловсруулан ариун цэвэр, эрүүл ахуйн аян зохион байгуулан мэдээлэл түгээх ажлын удирдамжыг боловсруулан тус ажилд | 1-6 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | эдгээрээс ялгарах бохир ус, ялгадас нь хөрсөнд шингэн, гүний усны бохирдолд шууд нөлөөлж байна. Судалгаагаар нийслэлийн хөрсний 88 хувьд нян, хөгц, мөөгөнцөр илэрсэн нь ариун цэврийн дэд бүтцийн дутагдал хүний эрүүл мэндэд шууд сөрөг нөлөө үзүүлж байгааг баталж байна. Судалгаанд үндэслэн төсөл боловсруулах. | | | үүлсэн байна. | шаардлагатай төсвийг тооцож санхүүжилтийг НҮБ-ын хүүхдийн сангаас гаргуулахаар шийдвэрлүүлсэн.<br><br>Эхний 5 сарын байдлаар ewater.mn цахим системээр ирүүлсэн 94 хаягдал усны дүгнэлт гаргуулах хүсэлт, егр-emongolia.mn цахим системээр 28 албан бичиг хүлээн авч, 16 бичиг төлөвлөн, 56 байгууллагад хүргүүлсэн байна. | | |
| 3. | **Үүрэг даалгавар 3.**<br>Тендерийн ажлыг зохион байгуулах. | - | - | Тендерийн баримт бичгийг боловсруу лж, зарласан байна. | Эгийн голын усан цахилгаан станц" төслийн Сэлэнгэ мөрний сав газрын экосистемд үзүүлэх өөрчлөлтийг тодорхойлох судалгааны ажилд зориулж багаж, тоног төхөөрөмж, программ хангамж худалдаж авах бичиг баримтыг боловсруулж, тендерийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр зарласан. | 1-6 | 100% |
| 4. | **Үүрэг даалгавар 4.**<br>Аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдол хүсэлтийн хариуг хуулийн хугацаанд түргэн, шуурхай шийдвэрлэх ажлын үр дүнг сайжруулах. | - | - | | Эхний хагас жил 2 албан бичгийг хүлээн авч 2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр албан бичгээр хариуг хугацаанд нь хүргүүлсэн. Хуулийн хэрэгжилтийг хангуулах болон санал хүсэлтийг нийт 4 албан бичгийг холбогдох газруудад хүргүүлсэн. Мөн Усны газрын 3 дүгнэлтийн хурлын тэмдэглэлийг хөтлөн, баталгаажуулсан. | 1-6 | 100% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | **Арга хэмжээ 1**. Агентлаг болон холбогдох төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд зохиогдсон сургалт, семинарт хамрагдах | Хамрагдсан сургалтын тоо | 2024 онд 3 сургалт, семинарт хамрагдсан. | Сургалт, семинарт хамрагдсан байна | 1. Авилгын эсрэг сургагч багш 2 өдрийн сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан.<br>2. ISO9001 чанрын стандартын сургалтад хамрагдсан. | 1-6 | 100% |
| 2. | **Арга хэмжээ 2.** Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Худалдан авах | Худалдан авах | - | Худалдан авах ажиллагааны | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр | 1-6 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааны газраас "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх А3 сургалтад хамрагдах | ажиллагааны мэргэшүүлэх А3 сургалтад хамрагдах. | | мэргэшүүлэх А3 сургалтад хамрагдсан байна.- | бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтанд амжилтай оролцсон тул 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр гэрчилгээ авсан. | | |
| 3. | **Арга хэмжээ 3.** Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад хамрагдах. | Суралцсан кредит цаг | - | 11 кредит цаг | Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад хамрагдаж Удирдлагын академийн захирлын 2025 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр А/45 тоот тушаалаар сертификат авсан. | 1-6 | 100% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

ХАЯГДАЛ УСНЫ ТӨЛБӨР ТООЦОО ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН .................................. / Б.БОЛОР-ЭРДЭНЭ/ 2025 оны 06 дугаар 05-ны өдөр

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*